



ХУУЛЬ ЭРХ, ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

2024 он 11, 12 сар №51

АКР Хуулийн фирм

Та бүхэнд Шинэ жилийн мэнд хүргэе. Манай хуулийн фирмтэй бүтэн жилийн турш хамт байж, бидний гаргадаг Хууль эрх зүйн мэдээллийг уншдаг, түгээдэгт тань бид Гүнээ талархал илэрхийлж байна.



Бид энэ оны 11 болон 12 сард батлагдсан онцлох **ХУУЛЬ ТОГТООМЖ**-с танилцуулж байна.

① 2025 оны төсөв, түүнтэй холбогдох бусад хууль тогтоомжууд батлагдлаа. Үүнд:

- ✖ Монгол улсын 2025 оны төсвийн тухай
- ✖ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль
- ✖ Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай
- ✖ Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай
- ✖ Монгол улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл зэрэг 5 хууль тогтоомж батлагдсан байна.

② Цөмийн материал, түүнтэй холбоотой олон улсын гэрээнүүдийг соёрхон баталлаа. Үүнд:

- ✖ Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол
- ✖ Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц
- ✖ Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт гэх мэт 3 олон улсын гэрээг соёрхон баталлаа.

③ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна. Тодруулбал,

Татварын хөнгөлөлтийн талаар

- ✖ 2025.01.01 өдрөөс хойш хэрэгжүүлэх

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг 5 жил 90 хувиар;

- ✖ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа зэрэгт ААНОАТ-ын хөнгөлөлт үзүүлэхээр болсон.

Тайлантай холбогдуулан

- ✖ Хуулийн 27.1.6-д заасан төгрөгийн ханшийг Татварын ерөнхий газраас татварын жилийн 01-р сард багтаан өөрийн цахимд хуудсанд байршуулна.

Хүчингүй болсон заалт (хасагдах зардлаас хасагдсан зардал)

- ✖ Асрамж, халамжийн байгууллагын үйл ажиллагаагаа явуулах байр, түүний тохижилт, өргөтгөлд өгсөн дэмжлэг, хандив
- ✖ Виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд олгосон тусламж зэрэг нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогдохгүй боллоо.

④ Гаалийн тариф, гаалийн татварын хуульд мөн нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Гаалийн татвараас чөлөөлөх талаар

- ✖ Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмж нь гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

Гаалийн татварын хөнгөлөлтийн талаар

- ✖ Газар тариалангийн болон боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдэл, трактор, комбайны гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлнө.

⑤ Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✖ Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг хуулийн этгээд ашиглах тохиолдолд төр хамгийн багадаа, тухайн хуулийн этгээдийн 34-51 хувийн хувьцааг эзэмшигч байна.
- ✖ Дээрх хувьцааг УИХ-ын шийдвэрээр давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой.
- ✖ Уг салбарт үйл ажиллагаа эрхлэгч этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлнө.
- ✖ Цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохыг хориглоно.
- ✖ Цацраг идэвхт хаягдлын менежментийг уг салбарт үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй этгээд бүрэн хариуцна.
- ✖ Дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн нөхөн сэргээлт, засвар арчилгааны мөнгөн хөрөнгийг урьдчилж байршуулна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭР

- ① Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15-р зүйлийн 4 дэх хэсэг Үндсэн хууль зөрчсөн байх тул хүчингүй болгов.
(ҮХЦ-ийн 2024.11.08, Дугаар 02 тогтоол)
- ② Татварын ерөнхий хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэг Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэв.
(ҮХЦ-ийн 2024.11.22, Дугаар 04 дүгнэлт)
- ③ Цагдаагийн албаны тухай хуулийн 69-р зүйлийн 69.1 дэх хэсэг нь Үндсэн хууль зөрчсөн байх тул хүчингүй болгов.
(ҮХЦ-ийн 2024.11.27, Дугаар 03 тогтоол)

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦЛОХ ТОГТООЛ

- ① Монгол Улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг баталсан.
(ЗГ-ийн 2024.11.20, Дугаар 182 тогтоол)
- ② Цахилгаан эрчим хүчийг хэмжих, тооцох зориулалттай хэмжих хэрэгслийн техникийн зохицуулалтыг баталсан.
(ЗГ-ийн 2024.11.20, Дугаар 180 тогтоол)
- ③ Тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
(ЗГ-ийн 2024.12.18, Дугаар 221 тогтоол)

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТУШААЛААР БАТЛАГДСАН ОНЦЛОХ ДҮРЭМ, ЖУРАМ

- ① Санхүүгийн тайлагналын зориулалттай хөрөнгийн үнэлгээ хийх журам болон

Санхүүгийн тайлагналын зориулалттай хөрөнгийн үнэлгээ хийх аргачлал

(Сангийн сайдын 2024.11.19, Дугаар А/207 тушаал)

- ② Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам
(Сангийн сайдын 2024.11.18, Дугаар А/205 тушаал)
- ③ Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам
(Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.11.15, Дугаар А/54 тушаал)
- ④ Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм /бнбд 12-02-24/-ийн шинэчилсэн найруулга
(Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.12, Дугаар 125 тушаал)
- ⑤ Нийслэл хотод автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгох шалгуур үзүүлэлт
(Нийслэлийн засаг даргын 2024.11.15, Дугаар А/1348 захирамж)
- ⑥ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
(СЗХ-ны 2024.11.25, Дугаар 555 тогтоол)
- ⑦ Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам
(СЗХ-ны 2024.11.25, Дугаар 555 тогтоол)

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Pearl tower А блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414